



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 01

Сүхбаатар сум

“Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн
мэдлэгийг дээшлүүлэх жил” болгон зарлах тухай


Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн 2.2.3 дахь зорилт, Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 13 тоот тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.3 дахь заалт, Төрийн албаны Зөвлөлийн 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.7.2, 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн байгууллагуудын албан бичиг хэргийг 2022 оноос эхлэн кирилл болон Монгол бичгээр хөтлөн явуулах туршилтыг явуулж, 2025 оноос эхлэн нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх болсонтой холбогдуулан Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлөөс 2021-2022 оныг “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх жил” болгон зарласугай.

2. Зарласан жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталж, хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Төрийн албаны Зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож, танилцуулахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ш.Энхмаа/-д даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон зарласан жилийн хүрээнд сум, байгууллагын хэмжээнд санаачлан хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайланг жил бүрийн 12-р сарын 01-ний дотор Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлд ирүүлэхийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

4. Төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай хандаж, үндэсний бичгээ шамдан суралцахыг нийт төрийн албан хаагчдадаа уриалсугай.

ДАРГА  Ө.СУВДАА
УХАА 0116
15